СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>www.open.audit.mn<br>Сүхбаатар сум<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх<br>Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Ц.Отгонбаяр<br>Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn<br><br>Аудитор: Ж.Баясгалан<br>Утас: 7036-3047 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
Б.МӨНХТӨР ТАНАА

2026.02.13 № СТА-2026/183/НА-СТА-ТШЗ
танай ____________-ны № ______________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/142 дугаар тушаалын дагуу 4,249.8 мянган төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг суурин компьютер, 08 дугаар сарын 11-ний өдрийн А/374 дүгээр тушаалын дагуу 15,955.3 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг суурин, 1 ширхэг зөөврийн компьютер нийт 20,205.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэл тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Тариалангийн талбайн хөрс хамгаалах, үржил шимийг дээшлүүлэх” арга хэмжээний хүрээнд тариалан эрхлэгч


4326050042

иргэд, аж ахуйн нэгүүдэд 5 жилийн хугацаатай ашиглуулж, гэрээний хугацаа дуусахад тариаланчид шилжүүлэхээр 251.7 мянган төгрөгийн өртөг бүхий 24.9 мянган ширхэг нийт 6,279,397.9 мянган төгрөгийн үнэтэй бетон шонг хүлээн авч, хүсэлт өгсөн тариалан эрхлэгчдэд ашиглалтын гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 20 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 88.1 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТМӨНХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тод-руулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **823,811,007.18** | **7,359,333,967.06** |
| **33** | **АВЛАГА** | **4** | **75,412,921.38** | **107,569,687.26** |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | | - | 755,000.00 |
| **33500** | **Бусад авлага** | | **75,412,921.38** | **106,814,687.26** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | | 42,820,743.89 | 54,452,634.49 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | **6** | 32,592,177.49 | 52,362,052.77 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | | **748,398,085.80** | **7,251,764,279.80** |
| 35100 | Түүхий эд материал | | 575,926,905.80 | 7,076,443,159.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 575,926,905.80 | 7,076,443,159.80 |
| 35400 | Хангамжийн материал | | 156,471,180.00 | 159,321,120.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 2,766,580.00 | 2,164,520.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 808,000.00 | 808,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | - | 2,600,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | **7** | 1,145,000.00 | 847,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 151,751,600.00 | 152,901,600.00 |
| 35600 | Мал амьтад | | 16,000,000.00 | 16,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **700,709,557.64** | **560,715,106.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | | **700,709,557.64** | **560,715,106.16** |
| 39200 | Биет хөрөнгө | | 425,731,057.64 | 285,736,606.16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 198,695,396.80 | 198,695,396.80 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | -55,581,935.92 | -79,790,934.16 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 176,650,000.00 | 176,650,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | -169,275,000.26 | -172,441,666.94 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | | 290,060,680.65 | 310,265,770.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | -202,838,754.37 | -243,693,167.29 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 28,836,333.77 | 28,836,333.77 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | **9** | -25,786,336.17 | -27,226,336.65 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 399,393,990.09 | 399,393,990.09 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | -214,423,316.95) | -304,952,780.11 |
| 39300 | Биет бус хөрөнгө | | 274,978,500.00 | 274,978,500.00 |
| 39301 | Программ хангамж | | 6,800,000.00 | 6,800,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | -6,800,000.00 | -6,800,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 274,978,500.00 | 274,978,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | | **1,524,520,564.82** | **7,920,049,073.22** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **15,691,582.39** | **14,525,927.45** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **15,691,582.39** | **14,525,927.45** |
| 41300 | Өглөг | | 15,691,582.39 | 14,525,927.45 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | - | 5,345,714.98 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | - | 7,450,113.47 |
| 41360 | Бусад өглөг | | 15,691,582.39 | 1,730,099.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 15,691,582.39 | 975,099.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | | - | 755,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **1,508,828,982.43** | **7,905,523,145.77** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **1,508,828,982.43** | **7,905,523,145.77** |
| **51100** | **Засгийн газрын оруулсан капитал** | | **1,076,727,589.41** | **1,076,727,589.41** |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | 1,076,727,589.41 | 1,076,727,589.41 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | | **346,674,824.74** | **6,743,368,988.08** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | -108,885,570.52 | 346,674,824.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 455,560,395.26 | 6,396,694,163.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 85,426,568.28 | 85,426,568.28 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | | **1,524,520,564.82** | **7,920,049,073.22** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тод-руул-га | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **2** | **2,551,286,636.75** | **7,832,429,711.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **1,246,786,519.25** | **7,832,429,711.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | **1,246,786,519.25** | **6,695,630,411.20** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 18,611,366.62 | 20,205,090.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 1,228,175,152.63 | 6,675,425,321.20 |
| **122** | **Тусламжийн орлого** | | **-** | **1,136,799,300.50** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | | **-** | **1,136,799,300.50** |
| 12211 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | | - | 1,023,195,800.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | - | 1,023,195,800.00 |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **-** | **113,603,500.50** |
| 122133 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | - | 113,603,500.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **1,304,500,117.50** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | **1,081,710,700.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,081,710,700.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **222,789,417.50** | **-** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 220,943,337.50 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,846,080.00 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | **1,614,387,345.49** | **1,419,463,548.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3** | **1,614,387,345.49** | **1,419,463,548.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **1,359,879,301.96** | **1,371,137,969.13** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **702,355,689.65** | **746,248,144.38** |
| 210101 | Үндсэн цалин | | 388,077,241.45 | 390,910,376.81 |
| 210102 | Нэмэгдэл | | 236,752,890.50 | 239,426,743.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 22,693,611.40 | 66,664,426.83 |
| 210104 | Урамшуулал | | 54,831,946.30 | 49,246,597.68 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **88,586,267.64** | **100,950,518.29** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | | 61,186,428.19 | 62,962,664.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | | 7,211,890.05 | 7,343,060.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | | 3,651,044.02 | 3,629,290.57 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | | 3,309,781.08 | 3,516,100.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | | 13,227,124.30 | 23,499,402.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **21,261,439.48** | **25,438,608.98** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 1,782,000.48 | 2,380,168.23 |
| 210302 | Түлш, халаалт | | 17,973,649.00 | 19,314,700.75 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 1,505,790.00 | 3,743,740.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **75,348,650.00** | **54,568,335.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 4,700,600.00 | 4,733,060.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 64,718,520.00 | 43,505,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 2,452,230.00 | 2,089,075.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | - | 140,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3,477,300.00 | 4,101,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **250,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 250,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **9,770,100.00** | **9,020,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 3,080,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | | 6,690,100.00 | 9,020,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **72,800,200.00** | **30,710,100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 72,800,200.00 | 30,710,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **77,768,810.20** | **142,522,721.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 66,242,317.20 | 138,934,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 2,899,500.00 | 2,700,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 324,160.00 | 107,221.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 154,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 7,926,000.00 | 660,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 222,833.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **311,738,144.99** | **261,679,541.48** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 127,616,772.00 | 96,847,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | - | 4,633,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 184,121,372.99 | 160,199,541.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **254,508,043.53** | **48,325,579.23** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **97,914,905.97** | **6,624,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 7,400,000.00 | 5,724,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 8,411,185.97 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 81,678,720.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 425,000.00 | 900,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **156,593,137.56** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 21,954,953.65 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 134,638,183.91 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **-** | **56,418,062.60** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | - | 56,418,062.60 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **936,899,291.26** | **6,412,966,163.34** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **481,338,896.00** | **16,272,000.00** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 481,338,896.00 | 16,272,000.00 |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | | **-481,338,896.00** | **-16,272,000.00** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | | **455,560,395.26** | **6,396,694,163.34** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,451,056,432.50** | **1,187,349,601.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **1,187,349,601.80** |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **1,187,349,601.80** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | **-** | **1,187,349,601.80** |
| **12211** | **Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого** | **-** | **1,023,195,800.00** |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 1,023,195,800.00 |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **164,153,801.80** |
| 122133 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 113,603,500.50 |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 809,500.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 49,740,801.30 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,451,056,432.50** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,081,710,700.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,081,710,700.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **369,345,732.50** | **-** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 220,943,337.50 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,874,050.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 145,528,345.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,443,836,432.50** | **1,187,349,601.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,443,836,432.50** | **1,187,349,601.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,189,328,388.97** | **1,124,307,539.20** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **702,355,689.65** | **750,337,430.99** |
| 210101 | Үндсэн цалин | 388,077,241.45 | 394,459,428.11 |
| 210102 | Нэмэгдэл | 236,752,890.50 | 239,426,743.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,693,611.40 | 66,664,426.83 |
| 210104 | Урамшуулал | 54,831,946.30 | 49,786,832.99 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **88,586,267.64** | **91,515,516.70** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 61,186,428.19 | 62,962,664.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 7,211,890.05 | 7,343,060.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 3,651,044.02 | 3,629,290.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 3,309,781.08 | 3,516,100.67 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 13,227,124.30 | 14,064,400.63 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **21,261,439.48** | **21,611,531.15** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,782,000.48 | 2,380,168.23 |
| 210302 | Түлш, халаалт | 17,973,649.00 | 15,487,622.92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,505,790.00 | 3,743,740.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **60,851,410.00** | **52,287,239.36** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,277,000.00 | 2,660,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,581,880.00 | 40,710,664.36 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,452,230.00 | 1,654,375.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 140,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,540,300.00 | 7,121,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **250,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 250,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,481,100.00** | **12,500,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,591,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 7,890,100.00 | 12,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **72,800,200.00** | **30,710,100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 72,800,200.00 | 30,710,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **100,125,510.20** | **143,122,721.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 88,599,017.20 | 139,534,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,899,500.00 | 2,700,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 324,160.00 | 107,221.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 154,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,926,000.00 | 660,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 222,833.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **127,616,772.00** | **22,223,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 127,616,772.00 | 17,590,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 4,633,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **254,508,043.53** | **63,042,062.60** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **97,914,905.97** | **6,624,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,400,000.00 | 5,724,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 8,411,185.97 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 81,678,720.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 425,000.00 | 900,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **156,593,137.56** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,954,953.65 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 134,638,183.91 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **56,418,062.60** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 56,418,062.60 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **7,220,000.00** | **-** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **7,220,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,220,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **7,220,000.00** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,220,000.00 | - |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-7,220,000.00** | **-** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(VIII)=(III)+(VI)+(VII)** | **-** | **-** |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээ-ний нэмэг-дэл | Хуримтлагдсан үр дүн | Хянал-тын бус хувь орол-цоо | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **806,717,089.41** | **85,426,568.28** | **-108,885,570.52** | **0.00** | **783,258,087.17** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 806,717,089.41 | 85,426,568.28 | -108,885,570.52 | 0.00 | 783,258,087.17 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 270,010,500.00 | - | - | 0.00 | 270,010,500.00 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 455,560,395.26 | 0.00 | 455,560,395.26 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,076,727,589.41** | **85,426,568.28** | **346,674,824.74** | **0.00** | **1,508,828,982.43** |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,076,727,589.41** | **85,426,568.28** | **346,674,824.74** | **0.00** | **1,508,828,982.43** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,076,727,589.41** | **85,426,568.28** | **346,674,824.74** | **0.00** | **1,508,828,982.43** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 6,396,694,163.34 | 0.00 | 6,396,694,163.34 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,076,727,589.41** | **85,426,568.28** | **6,743,368,988.08** | **0.00** | **7,905,523,145.77** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **1,139,898,400.00** | **1,018,112,800.00** | **121,785,600.00** | **89.32** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **12** | **Татварын бус орлого** | **1,139,898,400.00** | **1,018,112,800.00** | **121,785,600.00** | **89.32** |
| **122** | **Тусламжийн орлого** | **1,139,898,400.00** | **1,018,112,800.00** | **121,785,600.00** | **89.32** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,139,898,400.00 | 1,018,112,800.00 | 121,785,600.00 | 89.32 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,139,898,400.00** | **1,018,112,800.00** | **121,785,600.00** | **89.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,139,898,400.00** | **1,018,112,800.00** | **121,785,600.00** | **89.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,133,174,400.00** | **1,011,488,800.00** | **121,685,600.00** | **89.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **698,531,600.00** | **676,028,746.15** | **22,502,853.85** | **96.78** |
| 210101 | Үндсэн цалин | 409,579,500.00 | 394,459,428.11 | 15,120,071.89 | 96.31 |
| 210102 | Нэмэгдэл | 219,393,300.00 | 165,118,058.22 | 54,275,241.78 | 75.26 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,930,600.00 | 66,664,426.83 | (31,733,826.83) | 190.85 |
| 210104 | Урамшуулал | 34,628,200.00 | 49,786,832.99 | (15,158,632.99) | 143.78 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **91,614,700.00** | **82,391,762.34** | **9,222,937.66** | **89.93** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,549,800.00 | 56,811,257.35 | 6,738,542.65 | 89.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,023,900.00 | 6,599,974.04 | 423,925.96 | 93.96 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,510,700.00 | 3,257,747.03 | 252,952.97 | 92.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,506,200.00 | 3,144,556.79 | 361,643.21 | 89.69 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,024,100.00 | 12,578,227.13 | 1,445,872.87 | 89.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **28,092,800.00** | **21,611,531.15** | **6,481,268.85** | **76.93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,695,000.00 | 2,380,168.23 | 7,314,831.77 | 24.55 |
| 210302 | Түлш, халаалт | 14,551,200.00 | 15,487,622.92 | (936,422.92) | 106.44 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,846,600.00 | 3,743,740.00 | 102,860.00 | 97.33 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **70,861,900.00** | **50,090,939.36** | **20,770,960.64** | **70.69** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,740,000.00 | 2,660,300.00 | 3,079,700.00 | 46.35 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 52,492,100.00 | 39,996,164.36 | 12,495,935.64 | 76.19 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,850,000.00 | 1,654,375.00 | 195,625.00 | 89.43 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140,000.00 | 140,000.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,639,800.00 | 5,640,100.00 | 4,999,700.00 | 53.01 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,750,000.00** | **12,500,000.00** | **250,000.00** | **98.04** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 250,000.00 | - | 250,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 12,500,000.00 | 12,500,000.00 | - | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **39,988,600.00** | **30,710,100.00** | **9,278,500.00** | **76.80** |
| 210702 | Дотоод албан томилолт | 39,988,600.00 | 30,710,100.00 | 9,278,500.00 | 76.80 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **164,622,400.00** | **133,522,721.00** | **31,099,679.00** | **81.11** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 154,244,300.00 | 129,934,500.00 | 24,309,800.00 | 84.24 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,700,000.00 | 2,700,000.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 305,000.00 | 107,221.00 | 197,779.00 | 35.15 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 128,100.00 | 121,000.00 | 7,100.00 | 94.46 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,200,000.00 | 660,000.00 | 6,540,000.00 | 9.17 |
| 210807 | Газрын төлбөр | 45,000.00 | - | 45,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **26,712,400.00** | **4,633,000.00** | **22,079,400.00** | **17.34** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,342,400.00 | - | 21,342,400.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,370,000.00 | 4,633,000.00 | 737,000.00 | 86.28 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,724,000.00** | **6,624,000.00** | **100,000.00** | **98.51** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **6,724,000.00** | **6,624,000.00** | **100,000.00** | **98.51** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,724,000.00 | 5,724,000.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 900,000.00 | 100,000.00 | 90.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **25.00** | **25.00** | **-** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 20.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | | **112,818.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **112,818.70** |
| **122** | **Тусламжийн орлого** | | **112,818.70** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | | **112,818.70** |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **112,818.70** |
| 122133 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 112,818.70 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **112,818.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **112,818.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **112,818.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **74,308.70** |
| 210102 | Нэмэгдэл | | 74,308.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **9,123.70** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 6,151.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 743.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 371.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 371.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 1,486.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **1,741.80** |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 260.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, | | 1,481.80 |
| **2108** | **Мэргэжлийн үйлчилгээний төлбөр** | | **9,600.00** |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | | 9,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **18,044.50** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 18,044.50 |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/21 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,614,387.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,143.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сонин, хэвлэл, сэтгүүлийн захиалга хийгээгүй,
- Мэдээлэл, технологийн зардлаас 6,540.0 мянган төгрөгийн төсвийг хэмнэсэн,
- Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг 5 автомашинд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэж байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн газар нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 431 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,156.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 932,293.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 2,757.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 1,156.8 | 1 | 1,156.8 | 100.0 |
| Албан шаардлага | 2 | 932,293.4 | 2 | 832,293.4 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | 2,757.9 | 2 | 2,757.9 | 100.0 |
| **Нийт дүн** | **5** | **32,707.8** | **5** | **32,707.8** | **100.0** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- ✓ ХХААХҮЯ-наас мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардалд 120,157.5 мянган төгрөгийг “Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж” зардалд бөөн дүнгээр баталж, хэрэгжүүлсэн байгаа нь төсвийн гүйцэтгэлийг арга хэмжээ, эдийн засгийн ангилал, зардлын зүйлээр хянах төрийн сангийн хяналтыг сулруулж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 75,838.0 мянган төгрөгийн дараах алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирсэн 30 тонн Элит төмсний үрийг худалдан борлуулсан боловч бараа материалын бүртгэл тайланд 20 тонн буюу 35,140.0 мянган төгрөгийг үлдэгдэлтэйгээр тайлагнасан,
- Мөн яамнаас ирсэн 58 тонн Хошуу буудайн /Овьёосны үр/ үрийг тарааж дууссан боловч 25.5 тонн буюу 40,698.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх *“... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”*, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 167,966.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 798.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 167,618.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хуваарилсан хошуу буудайн үрийг газар тариалан эрхэлж буй иргэн, ААН-д олгохдоо гэрээнд урьдчилгаа төлүүлэхээр тусгасан боловч 1 иргэнд урьдчилгаа төлбөрийн 20 хувь болох 798.0 мянган төгрөгийг төлүүлэлгүйгээр олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно"*, Хошуу буудайн үр худалдах, худалдан авах гэрээний 2 дугаар зүйлийн 2.4 дэх *"Худалдан авагч хошуу буудай буюу овьёосны үрийн урьдчилгаа 20 хувийн төлбөрийг төлж авна, үлдэгдэл 80 хувийн төлбөрийг ургац хурааж дууссаны дараа ..."* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Гэрээнд заагдсан урьдчилгаа төлбөрийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

*<u>1.1 Илрүүлэлт</u>*: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **70** нэр төрлийн хөрөнгийг */Нийт хөрөнгийн 64 хувь/* бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т *"илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох"* гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Хөрөнгийг дахин үнэлэх болон актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

*<u>1.2 Илрүүлэлт</u>*: Хүнс, хөдөө аж ахуйн нэр дээр бүртгэж, гэрчилгээ авсан 123,618.0 мянган төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгийн бүртгэл тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*", 14.4.2 дахь *"Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Бүртгэлгүй хөрөнгийг үндсэн хөрөнгийн бүртгэл тайланд тусгах.

**2 Бараа материалын данстай холбоотой асуудал:**

*<u>1 Илрүүлэлт</u>*: Тайлант онд ашигласан 43,550.0 мянган төгрөгийн түлш, шатахууныг сар бүр бөөн дүнгээр зарлагадсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх *"... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон*

*цахимаар бичилт хийж баталгаажуулна"*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт *"Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"*-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*: Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5[1] дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[1] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан | 2 | 75,838.0 | | | 2 | 75,838.0 | 2 | 75,838.0 | | | | |
| Нийт дүн | **2** | **75,838.0** | | | **2** | **75,838.0** | **2** | **75,838.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөр-ийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | А/туш тоо | Тоо | Дүн |
| Гэрээнд заагдсан урьдчилгаа төлбөрийг төлүүлээгүй | 1 | 798.0 | 1 | 798.0 | | | | | | | | |
| Хөрөнгийг дахин үнэлээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй | 1 | 123,618.0 | | | | | 1 | 123,618.0 | | | | |
| БМ-ын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр хийгээгүй | 1 | 43,550.0 | | | | | 1 | 43,550.0 | | | | |
| **Нийт дүн** | **4** | **167,966.0** | **1** | **798.0** | | | **3** | **167,168.0** | | | | |